



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/13/-НА-СТА-ТТЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 3 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ | 4 |
| 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ | 5 |
| 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ | 6 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/ | 7 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/ | 9 |
| 3. Аудитын тайлан | 11 |
| 3.1. Ерөнхий зүйл | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 12 |
| 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт | 12 |
| 3.5.1 Орлогын данс | 13 |
| 3.5.2 Зардлын данс | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 13 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 14 |
| 3.8 Аудитын гол асуудал | 14 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СХС | Сум хөгжүүлсэн сан |



ХӨХМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.НАРАНБАДРАХ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 179
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020490

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|-------|---|-----------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 694,560.8 | 833,411.1 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 55,933.6 | 104,699.3 |
| 33 | АВЛАГА | 380,105.3 | 446,070.2 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 223,342.1 | 253,466.3 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 25,179.8 | 29,175.3 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 10,000.0 | 0.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,648,966.4 | 3,447,650.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,648,966.4 | 3,447,650.0 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,610,532.6 | 3,409,407.0 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 38,433.8 | 38,243.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 4,343,527.2 | 4,281,061.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,750.0 | 59,544.9 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,750.0 | 59,544.9 |
| 41300 | Өглөг | 1,750.0 | 59,544.9 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,341,777.2 | 4,221,516.2 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,341,777.2 | 4,221,516.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,905,093.3 | 1,905,093.3 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,230,837.3 | 1,110,576.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,205,846.6 | 1,205,846.6 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 4,343,527.2 | 4,281,061.1 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|--|-----------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,267,029.1 | 2,704,895.5 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 57,739.8 | 73,064.6 |
| 110 | Орлогын албан татвар | 52,559.3 | 49,628.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 52,559.3 | 49,628.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 600.0 | 18,665.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 4,580.5 | 4,771.2 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 304,714.9 | 349,497.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 304,255.4 | 349,497.6 |

| | | | |
|------|--|-------------|-------------|
| 122 | Тусламжийн орлого | 459.5 | 0.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,904,574.3 | 2,282,333.4 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,163,795.3 | 2,648,505.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,163,795.3 | 2,648,505.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,321,791.1 | 2,575,178.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,454,238.5 | 1,499,374.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 187,527.7 | 198,626.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 155,273.9 | 147,087.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 77,616.7 | 96,381.0 |
| 2105 | Нормативт зардал | 60,008.6 | 237,543.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,740.9 | 11,882.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,110.0 | 2,368.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,407.7 | 13,438.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 329,867.2 | 368,477.1 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 842,004.2 | 73,327.3 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 103,233.8 | 56,389.9 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 80,169.3 | 180,237.2 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 23,064.5 | -123,847.4 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,031,536.9 | 2,365,320.1 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 57,739.8 | 73,064.6 |
| 110 | Орлогын албан татвар | 52,559.3 | 49,628.2 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 52,559.3 | 49,628.2 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 600.0 | 18,665.2 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 4,580.5 | 4,771.2 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,492.8 | 3,911.8 |
| 1181 | Газрын төлбөр | 1,087.7 | 859.4 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 69,222.7 | 95,228.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 69,222.7 | 95,228.5 |

| | | | |
|------|--|-------------|-------------|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,904,574.3 | 2,197,027.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,854,400.2 | 2,126,498.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,854,400.2 | 2,126,498.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,010,916.2 | 2,053,208.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,452,768.5 | 1,496,694.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 186,037.3 | 198,166.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 168,818.8 | 142,624.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 79,297.2 | 87,251.4 |
| 2105 | Нормативт зардал | 47,374.9 | 73,433.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,584.6 | 11,869.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,110.0 | 2,368.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,473.8 | 13,438.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,451.0 | 27,362.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 843,483.9 | 73,290.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 177,136.7 | 238,821.8 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 90,649.9 | 125,056.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 90,649.9 | 125,056.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 90,649.9 | 125,056.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -90,649.9 | -125,056.0 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -50,000.0 | -65,000.0 |
| 14 | Бусад эх үүсвэр | 0.0 | 0.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 50,000.0 | 65,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 36,486.8 | 48,765.8 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 19,446.7 | 55,933.6 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 55,933.6 | 104,699.3 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Төсөвт байгууллага | Төрийн сан | Нэгтгэсэн нийт дүн |
|------|--|--------------------|------------|--------------------|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,322,422.3 | 10,834.8 | 4,333,257.1 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -14,544.4 | 0.0 | -14,544.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,307,878.0 | 10,834.8 | 4,318,712.7 |

| | | | | |
|----|--|-------------|----------|-------------|
| 9 | Тайлант үеийн үр дүн | 14,768.3 | 8,296.2 | 23,064.5 |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,322,646.3 | 19,131.0 | 4,341,777.2 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,322,646.3 | 19,131.0 | 4,341,777.2 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,586.4 | 0.0 | 3,586.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,326,232.6 | 19,131.0 | 4,345,363.6 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | -123,085.5 | -761.9 | -123,847.4 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,203,147.2 | 18,369.1 | 4,221,516.2 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|--------|---|---------------------|-----------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,327,120.60 | 2,245,505.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,125,027.30 | 2,082,950.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,100,542.10 | 2,058,494.38 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,512,927.10 | 1,495,510.38 |
| 210101 | Үндсэн цалин | 1,132,091.60 | 1,125,107.79 |
| 210102 | Нэмэгдэл | 158,051.50 | 180,132.61 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,800.00 | 2,897.00 |
| 210104 | Урамшуулал | 89,630.10 | 69,856.53 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 127,353.90 | 117,516.45 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 209,895.30 | 198,166.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 146,393.60 | 137,375.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,411.90 | 16,399.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 13,045.10 | 12,166.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,195.40 | 3,464.80 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 31,849.30 | 28,758.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 143,976.00 | 142,624.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,300.00 | 15,743.28 |
| 210302 | Түлш, халаалт | 127,726.00 | 126,625.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,950.00 | 255.00 |
| 210304 | Байрны түрээс | - | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 81,991.70 | 79,688.64 |

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|------------------|------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 8,247.20 | 7,055.09 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,067.20 | 48,779.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,245.00 | 3,008.30 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,299.50 | 2,297.30 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,554.70 | 1,505.80 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,578.10 | 17,042.55 |
| 2105 | Нормативт зардал | 78,461.80 | 72,097.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,395.00 | 22,884.55 |
| 210502 | Хоол, хүнс | 35,166.80 | 33,769.65 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 15,900.00 | 15,443.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 38,942.50 | 37,490.20 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,358.50 | 20,335.00 |
| 210602 | Тавилга | 7,000.00 | 6,975.70 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,480.00 | 1,470.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,104.00 | 8,709.50 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,050.00 | 2,141.20 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,050.00 | 2,141.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,667.70 | 3,214.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,279.70 | 1,060.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648.00 | 648.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 130.00 | 108.90 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110.00 | 106.19 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 80.00 | 66.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 580.00 | 580.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 360.00 | 175.45 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 480.00 | 469.46 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,630.00 | 27,562.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,250.00 | 24,244.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,380.00 | 3,318.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,485.20 | 24,456.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 24,485.20 | 24,456.20 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,945.20 | 15,945.20 |

| | | | |
|------------|---|---------------------|---------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,540.00 | 8,511.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 127,093.30 | 97,555.30 |
| 223001 | Бусад хөрөнгө | 127,093.30 | 97,555.30 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 75,000.00 | 65,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 75,000.00 | 65,000.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,327,120.60 | 2,293,754.99 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,475,102.70 | 1,457,341.50 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,475,102.70 | 1,457,341.50 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 726,558.00 | 742,599.60 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 624,464.70 | 640,506.30 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 102,093.30 | 102,093.30 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 23,859.90 | 3,995.53 |
| 330001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | - | - |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 23,859.90 | 3,995.53 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 101,600.00 | 89,818.36 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,100.00 | 88,541.74 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 48,400.00 | 1,276.62 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 34,100.00 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 35,052.61 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 83,301.73 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | | ТЗ цэвэр дүн |
|-------------|--|-------------------------|------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | Батлагдсан төсөв | 53,287.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 53,287.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 22,214.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 1,184.51 |
| 210101 | Үндсэн цалин | | 1,184.51 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 7,562.81 |
| 210401 | Бичиг хэрэг | | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 5,093.81 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 1,720.00 |

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|--|------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 649.00 |
| 2105 | Нормативт зардал | | 1,336.05 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 707.55 |
| 210502 | Хоол, хүнс | | 628.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 930.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 227.06 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 227.06 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 10,223.99 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 9,761.74 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 462.25 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 750.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 31,072.85 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 30,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 30,900.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 172.85 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 53,765.82 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 53,765.82 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 100.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 52,607.37 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 1,058.45 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | 478.55 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 478.55 |

3. Аудитын тайлан

3.10 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөхморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөхморьт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн эрх ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангах чиг үүрэг бүхий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа нэгж юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бугат сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.11 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.12 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлын 3,240.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 64.8 сая төгрөгөөр, төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 51.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт зардлаас 2,126.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 42.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34.0 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 62.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 104.9 сая төгрөг болж өссөн ба энэ өсөлтөд голлон орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 446.1 сая төгрөг болж өссөн нь сумын Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний авлага нэмэгдсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 253.5 сая төгрөг болж 30.1 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 387.5 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 151.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 506.9 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,222.8 сая төгрөг болж 141.6 сая төгрөгөөр буурсан. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 27.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 189.3 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр, 356.4 сая төгрөгийн хөрөнгийг акталж, шилжүүлсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 59.4 сая төгрөг болж 57.8 сая төгрөгөөр өссөн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанаас үүссэн өглөгийг нэмж бүртгэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,341.7 сая төгрөг болж 123.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 4,221.5 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 73.1 сая төгрөгийн татварын орлого, 95.2 сая төгрөгийн татварын бус орлого, 2,197.0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,365.3 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,648.5 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 180.2 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Хөхморьт сумын ИТХ-ын 2020 оны 12 дүгээр сарын “Сумын 2020 оны төсөв тодотгон батлах тухай” 08 дугаар тогтоолд зааснаар Хөхморьт сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 47.4 сая төгрөгийн татварын 2.0 сая төгрөгийн татварын бус нийт 49.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 59.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс хөрөнгийн орлогыг 4.2 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.13 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 2,327.1 сая төгрөгөөр баталсан байна

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 2,327.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас зардлын 1,475.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 624.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 102.1 сая төгрөгийг орон нутгийн

хөгжлийн сангаас, 23.8 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 34.1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 53.7 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 0.1 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 52.6 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.0 сая төгрөгийг тус тус тайлагнасан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.14 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.15 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.16 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 141 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.17 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд 2.2 сая төгрөгийн алдаа зөрчилд залруулга, 0.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн,

59.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. 35.5 сая төгрөгийн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Сум хөгжүүлэх сангийн төлөгдөөгүй актын үлдэгдэл 28.9 сая төгрөг байна. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдалд 2017-2018 онд хийсэн нийцлийн аудитаар өгөгдсөн 35.7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн урамшуулал болон амралттай холбоотойгоор тавигдсан төлбөрийн актаас 1.3 сая төгрөгийн актын үлдэгдлийг барагдуулаагүй байна.

Төсөв захирагч солигдсон тул мэдэгдэл хүргүүллээ.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

3.18 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитын шийдвэрийг хэрэгжилт, орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, хязгаарлалттай 3 дүгнэлт авсан байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 469.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 111.6 сая төгрөгийн алдааг залруулж, 19.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 337.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн зөрчил илэрч 0.7 сая төгрөгийн төлбөрийг акт 5.3 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүвэрт хамрагдсан байгууллагад залруулга хийгдээгүй болно.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төлбөрийн акт тогтоогоогүй болно

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Хөхморьт сумын ИТХ-ын урьдчилгаа 0.7 сая төгрөгийг суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14-т "Тухайн жилийн төсвийн хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтад шинэ арга хэмжээ нэмж тусгахгүйгээр, тэдгээрийн гүйцэтгэлийн явц байдалтай уялдуулан, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийх" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:

Шууд бус орлого 4.1 сая төгрөг, бууны татвар 0.034 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.04 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх "Хөхморьт сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоол гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:

Хөхморьт сумын ИТХ

Тайлант онд Е баримтгүй 1.1 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ

Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 2 сарын 7-ны өдрийн 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал,төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас, доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Хөхморьт сумын Соёлын төв

Батлагдсан төсвийн зардлын 10 хувийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 2 сарын 7-ны өдрийн 1.1-т/ үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал,төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас, доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах; гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Түүвэрт хамрагдсан байгууллага

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Хөхморьт сумын ИТХ

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансанд байршуулах мэдээллээс 2 мэдээллийн 12.1 сая төгрөгийг дутуу 2 мэдээллийг хугацаа хоцруулсан мэдээлсэн байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|-------------------------------------|----------------------|------------|-----------|-----|---------------|------------|-----------------|------------|----------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч | | | | | | | | | | | |
| | Хөхморьт сумын Төвлөрүүлэн захирагч | 1 | 4.2 | | | | | 1 | 4.2 | | |
| Түүвэрт хамрагдсан байгууллага | | | | | | | | | | | |
| | Соёлын төв | | | | | | | | | | |
| | ИТХ | 2 | 0.7 | | | 1 | 0.7 | 1 | | | |
| | Дүн | 4 | 4.9 | | | 1 | 0.7 | 2 | 4.2 | | |
| 3.19 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| Төсвийн төвлөрүүлэн захирагч | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | |
| | Соёлын төв | 1 | | | | | | 1 | | | |
| | ИТХ | 2 | 1.1 | | | | | 1 | 1.1 | 1 | |
| | Дүн | 3 | 1.1 | | | | | | | | |
| | Нийт дүн | 6 | 6.0 | | | 1 | 0.7 | 3 | 5.3 | 1 | |